# ХЭНТИЙ АЙМГИЙН
# БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2026 оны 09 сарын 02 өдөр    Дугаар А/138    Биндэр сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотариатын гэрээг үндэслэн “Эрхэм тоонот” ХХК-ий эзэмшлийн газрыг “МТ ойл” ХХК-д шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, хугацааг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн олгон, газар эзэмших гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч “Эрхэм тоонот” (6667481) ХХК-д даалгасугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2024 оны А/144 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА    Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

Сумын Засаг даргын 2026 оны 02-р сарын 02-ны
өдрийн А/138 дугаар захирамжийн хавсралт

| № | Газар эзэмшигчийн | | Газрын хаяг байршил | Газрын зориулалт | Газрын хэмжээ /м2/ | Өмнөх Захирамжийн | | Нэгж талбарын дугаар | Газар эзэмших хугацаа /жил/ | Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч байгаа иргэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нэр | Регистрийн дугар | | | | Огноо | Дугаар | | | Нэр | Регистрийн дугаар |
| 1 | “Эрхэм тоонот” ХХК | 6667481 | Залуус-1 102 | ШТС | 2000 | 2024.10.28 | А/144 | 2310002894 | 24 | “МТ ойл” ХХК | 6099866 |
| **Нийт дүн** | | | | | **2000** | | | | | | |